



ХААН БАНК

ХААН БАНК ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ГАРЫН АВЛАГА



ХААН Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гарын авлага

Эрхэм хүндэт хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид ээ,

ХААН Банк ХК ("Банк" гэх) нь энэхүү гарын авлагын хүрээнд хувьцаа эзэмшигч Та бүхэнд компанийн засаглал, хувьцаа эзэмшигчдийн эрх үүргийг таниулж мэдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн талаар болон Банкны талаарх бусад хэрэгцээт мэдээллийг өгөхөд оршино.

Банк нь нээлттэй хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигчдээ шаардлагатай мэдээ, мэдээллээр цаг хугацаанд нь хангаж, компанийн засаглал болон үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлж, засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан ажиллахыг зорьдог.

ХААН Банк ХК-д итгэж хөрөнгө оруулалт хийсэн хувьцаа эзэмшигч танд баярлалаа. Таны хөрөнгө оруулалт Банкны хөгжил дэвшилд дэмжлэг болоод зогсохгүй таны оролцоо бүх хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцсэн шийдвэрийг гаргахад бидэнд тусалдаг болохыг онцлон дурдахад таатай байна.

Хүндэтгэсэн,
ХААН Банк ХК

Агуулга

Бидний тухай	5
Банкны ерөнхий танилцуулга	6
Засаглал	7
Эрсдэлийн удирдлага	8
Хувьцаа эзэмшигчдийн хурал	9
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	11
Хувьцаа эзэмшигчдийн эрх	13
Төлөөлөн удирдах зөвлөл	14
Төлөөлөн удирдах зөвлөлийн чиг үүрэг	15
ТУЗ-ийн ажлын алба	17
Ногдол ашиг	18
Холбоо барих	19

Бидний тухай

1991 оноос хойших 33 жилийн хугацаанд ХААН Банк үнэнч харилцагч, хамтрагч байгууллагууддаа банк санхүүгийн бүхий л цогц үйлчилгээг хурдан шуурхай, тав тухтай, хамгийн хялбараар хүргэхээр ажиллаж байна. Монгол Улсын тэргүүлэгч банкны хувьд банк, санхүүгийн салбартаа амжилт бүтээлээрээ ялгаран, баялаг түүх, арвин туршлагыг бүтээлцэж, үндэсний хэмжээний тэргүүлэгч, хамгийн хүчирхэг арилжааны банк болон өргөжсөөр байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагчдынхаа санхүүгийн аялын алхам бүрд хамгийн шилдэг, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэнэ.

АЛСЫН ХАРАА

Харилцагчидтайгаа хамт эгнэгт өсөж хөгждөг, итгэл төгөлдөр банк байна.

УРИА ҮГ

Хамтын өсөлт төгөлдөр

ҮНЭТ ЗҮЙЛС

Хөгжил цэцэглэлтийн түүчээлэгч

Бидний үүрэг банкны үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ харилцагчид, ажилтнууд, хувьцаа эзэмшигчдээ өсөлт хөгжлийн замд хөтлөхөд чиглэнэ.

Тогтвортой хөгжилд манлайлагч

Бид нэг байрандаа зогсдоггүй. Тогтвортой бизнесийг бүтээхийн төлөө тасралтгүй суралцаж, дасан зохицож, улам сайжирдаг учраас харилцагчдаа зорьж буй ирээдүйд нь хүргэх ажлаа улам төгөлдөржүүлнэ.

Шилдэг цахим бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэгч

Харилцагч бүр шилдгийг хүлээн авах учиртай. Тиймээс бид ирээдүйн сайн сайханд хөтлөх санхүүгийн ухаалаг арга хэрэгсэл, бүтээгдэхүүн үйлчилгээгээр түүчээлнэ.

Итгэлт зөвлөгч

Харилцагчид маань хэдэн арваны турш санхүүгээ бидэнд даатгаж ирсэн билээ. Энэхүү хүндтэй үйлсийг бид бахархалтайгаар үргэлжлүүлж, найдвартай зөвлөх, итгэлтэй түнш байж, үргэлж сайны төлөө зүтгэх болно.

Банкны ерөнхий танилцуулга

(2023.12.31-ний байдлаар)

Компанийн оноосон нэр	ХААН Банк ХК
Үүсгэн байгуулагдсан огноо	1991.12.05
Регистрийн дугаар	2693321
Үйл ажиллагааны чиглэл	Банк, санхүү
Салбар, нэгжийн тоо	Улаанбаатар 87, Орон нутаг 452
Нийт харилцагчийн тоо	2.9 сая
Нийт хувьцаа эзэмшигчийн тоо	29,061
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК
Биржид бүртгүүлсэн огноо	2022.09.09
Үнэт цаасны үсгэн тэмдэг	KHAN
Үнэт цаасны код	MNOKHANO5637
Нийт гаргасан хувьцаа	1,912,198,000 ширхэг энгийн хувьцаа
Гүйцэтгэх удирдлага	Гүйцэтгэх захирал - Р. Мөнхтуяа
Нийт ажилтнуудын тоо	6063
Хаяг	ХААН Банк Цамхаг, Чингисийн Өргөн Чөлөө-6, Стадион Оргил-1, Хан-Уул Дүүрэг 15-р хороо, Улаанбаатар 17010, Монгол Улс
Утас	1800-1917, 7515-3333 (3221)
И-мэйл	investor_relations@khanbank.com
Вэб сайт	www.khanbank.com

Засаглал

Засаглалын бүтэц, түүний үйл ажиллагаа тогтвортой, сайн байх нь чанартай шийдвэр гаргалт, удирдлагын залгамж халааг оновчтой төлөвлөх, цаашид компани аль ч талаар бие даасан, хараат бус байж, хэтийн хөгжилд тууштай анхаарах нөхцлийг бүрдүүлж өгдөг. Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлснээр олон эерэг үр дүн бий болгодог.

Банк нь компанийн сайн засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудыг баримталж, эдгээрийг бодитой хэрэгжүүлснээр олон улсын үнэлгээний агентлагуудын дунд банкны байр сууриа батжуулж, Монголдоо банкны системийн ач холбогдол бүхий тэргүүлэгч банкны нэр хүндийг хадгалахаас гадна хөрөнгийн зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг олон давуу талтай юм.

Нээлттэй хувьцаат компанийн хувьд засаглалын олон улсын сайн туршлагаас суралцан засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан, холбогдох хууль, дүрэм журмуудын хэрэгжилтийг ханган улсдаа компанийн засаглалаар тэргүүлсэн үлгэр жишээ компани болохыг зорин ажиллаж байна.

БАНКНЫ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН 4 ҮНДСЭН ЗАРЧИМ

ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

Банк хууль ёсныхоо эрх ашгийн хүрээнд өөрт олгогдсон хэрэгжүүлж буй эрх мэдэл болон үүргээ бүрэн хариуцах хариуцлагатай байх

ИЛ ТОД БАЙДАЛ

Олон нийтэд өгөх аливаа мэдээллийг тухай бүрт нь үнэн зөвөөр ил тод тайлагнаж хуваалцах

ТАЙЛАГНАЛ

Банкны бүх оролцогч болон сонирхогч талуудад үйлдэл бүрээ тайлагнан итгэлцлийг бүрдүүлэх

ШУДАРГА БАЙДАЛ

Банкны бүх оролцогч болон сонирхогч талуудад шударга, тэгш, ялгаваргүй хандах нөхцлийг бүрдүүлэх

Эрсдэлийн удирдлага

ХААН Банк эрсдэлийн удирдлагаа Эрсдэлийн засаглал, Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (Risk appetite statement), Эрсдэлийн удирдлагын үйл явц гэсэн бүрдлээр удирдах тогтолцоог хэрэгжүүлдэг бөгөөд ингэхдээ эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо улам бэхжүүлэх, нэгдсэн байдлаар удирдах зорилгоор ISO 31000:2018 стандартыг нэвтрүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

ХААН БАНКНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТOLЦOО

ЭРСДЭЛИЙН ЗАСАГЛАЛ
(ХАМГААЛАЛТЫН 3 ШУГАМ)

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ
ЭРСДЭЛИЙН МЭДЭГДЭЛ (RISK
APPETITTE STATEMENT)

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН
ҮЙЛ ЯВЦ

GRC (GOVERNANCE, RISK,
COMPLIANCE) СИСТЕМ

СТРЕСС ТЕСТ, НӨӨЦ
ТӨЛӨВЛӨГӨӨ, ЭРСДЭЛИЙН
ЛИМИТҮҮД

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН
БОДЛОГО, ЖУРАМ, АРГАЧЛАЛ

ЭРСДЭЛҮҮД

Зээлийн эрсдэл, Хөврөх чадварын эрсдэл, Зах зээлийн эрсдэл, Үйл ажиллагааны эрсдэл, Мэдээлэл технологийн эрсдэл, Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, Хууль, комплаенсийн эрсдэл.

ХАМГААЛАЛТЫН ГУРВАН ШУГАМ

ХААН Банк “Хамгаалалтын гурван шугам”-ын загвараар эрсдэлийг удирдах үүрэг хариуцлагуудыг тохиромжтой байдлаар хуваарилан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг.

ХАМГААЛАЛТЫН ГУРВАН ШУГАМ

ХАМГААЛАЛТЫН 1-Р ШУГАМ

БИЗНЕСИЙН ЧИГЛЭЛҮҮД
БОЛОН ТЭДГЭЭРИЙГ ДЭМЖИХ
ФУНКЦҮҮД

Бизнес болон үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэлүүдийг хариуцан тасралтгүй удирдана

ХАМГААЛАЛТЫН 2-Р ШУГАМ

ЭРСДЭЛИЙН ФУНКЦ БОЛОН
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГАД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭГЧ
ФУНКЦҮҮД

Эрсдэлийн удирлагыг чиглүүлэх, эрсдэлийн удирдлагын үйл явцад хяналт шалгалт болон сорилт хийнэ

ХАМГААЛАЛТЫН 3-Р ШУГАМ

ДОТООД АУДИТЫН ФУНКЦ

Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн засаглал болон дотоод хяналтад хараат бусаар шалгалт хийнэ

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн тухай хуулийн 59.1, Банкны Дүрмийн 7.1-д заасны дагуу банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурал ("ХЭХ" гэх) нь ээлжит болон ээлжит бус хэлбэрээр хуралдах ба ээлжит хурлыг жил бүр ТУЗ-ийн хурлын шийдвэрээр 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор зарлан хуралдуулдаг.

Банкны хувьцаа эзэмшигч бүр ХЭХ-д оролцох, ХЭХ-ийн материалтай танилцах, өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой харгалзах саналаар хурлаар хэлэлцэж буй асуудлуудыг шийдвэрлэхэд санал өгөх эрхтэй. Банкны Дүрэмд заасны дагуу ХЭХ-аас гарах бүх шийдвэр нь тухайн хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар хүчин төгөлдөр болох зохицуулалттай буюу КтХ-аас өндөр хувиар хүчин төгөлдөр болдог.

ХЭХ нь Банкны Дүрмийн 7.2-т зааснаар дараах асуудлуудыг хэлэлцэх, шийдвэрлэх бүрэн эрхтэй байна. Үүнд:

1. Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу шинэчилсэн найруулгыг батлах;
2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар Банкныг өөрчлөн байгуулах;
3. Банкны өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
4. Банкны хэлбэрийг өөрчлөх;
5. Банкныг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
6. Банкны хувьцааг хуваах буюу нэгтгэх;
7. Монголбанкны мэдэгдлийг хүлээн авсны үндсэн дээр ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
8. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;
9. Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
10. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд их хэмжээний хэлцлийг батлах;
11. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;



12. Компанийн тухай хуульд заасны дагуу Банк өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
13. ТУЗ-ийн дарга, гишүүний бүрэн эрхийг тогтоох, хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, ТУЗ-ийн үйл ажиллагааны ерөнхий журмыг тогтоох;
14. Банкны тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар ТУЗ-өөс бэлтгэсэн тайланг хэлэлцэж батлах;
15. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх;
16. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
17. Хууль тогтоомж, Монголбанк, СЗХ-ны журам болон Банкны Дүрмээр тогтоосон бусад асуудал.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Банкны нийт гаргасан 1,912,198,000 ширхэг энгийн хувьцааг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 29,061 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

ХААН Банкны хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо (ш)	Хувь
Эйч Эс Холдингс ХК (Япон улс)	783,882,300	40.99%
Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед ХХК (Хонг Конг)	167,856,050	8.78%
Таван Богд Холдингс ХХК (Монгол Улс)	435,653,100	22.78%
Д.Хулан (Монгол Улс)	252,738,000	13.22%
АХХХ-ийн оролцогчид	80,848,750	4.23%
Олон нийт	191,219,800	10.0%
Нийт	1,912,198,000	100%


ЭЙЧ ЭС ХОЛДИНГС ХК

Токиогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Эйч Эс Холдингс” ХК (ТҮО: 8699) нь санхүүгийн бизнес эрхэлдэг компаниудын хувьцааг эзэмшдэг холдинг компани бөгөөд харилцан хамаарал бүхий 7 компанитай. Эдгээр нь Gaitame.com ХХК, Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед, Эйч Эс Секюритис ХХК, Эйч Эс Сэрвисэр ХХК, Солид Банк ХК, ХААН Банк ХК болон Кыргызкоммерцбанк ХК зэрэг болно.



ТАВАН БОГД ХОЛДИНГС ХХК

Таван Богд Холдингс ХХК нь Таван Богд Группийн толгой компани ба 1997 онд Группийн бодлого стратеги, менежментийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан. Таван Богд Групп нь худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл, аялал жуулчлал болон зочид буудал, уул уурхайн тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэлт, банк санхүү зэрэг салбарт үйл ажиллагаа явуулдаг.




Д.ХУЛАН

Монгол Улсын иргэн хатагтай Д.Хулан нь Таван Богд группийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч бөгөөд одоогоор тус группийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Тэрээр ХААН Банкны ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дэд дарга бөгөөд 2010 оноос банкны хувьцаа эзэмшигч болсон.




ЭЙЧ ЭС ИНТЕРНЭЙШНЛ ЛИМИТЕД (АЗИ) ХХК

“Эйч Эс Интернэйшнл” (Ази) Лимитед компани нь “Эйч Эс Холдингс” ХК-ийн 100 хувийн эзэмшилтэй Хонгконг дахь охин компани юм. Тус компани нь Хятад болон Ази тивийн эдийн засгийн өсөлт дээр тулгуурлан “Эйч Эс Холдингс” ХК-ийн Ази дахь стратегийг хэрэгжүүлж, бүс нутгийн улс орнуудын зах зээлийн судалгаа хийхээс гадна Хонконгийн зах зээл дээр бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг.



АЖИЛТАНД ХУВЬЦАА ХУДАЛДАХ ХӨТӨЛБӨРИЙН ОРОЛЦОГЧИД

ХААН Банкны хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 9 тоот тогтоолоор баталсан “ХААН Банкны ажилтанд хувьцаа худалдах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зөвшөөрлийг Монголбанкнаас 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр хүлээн авснаар тус Банкны 4,136 ажилтанд 80,848,750 ширхэг хувьцааг эзэмшүүлсэн. Ажилтанд хувьцаа худалдах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Банкны ажилтан нь нээлттэй компанийн бүтэц бүхий банкныхаа бизнесийн өсөлт, ашигт ажиллагаа, нийгмийн хариуцлагыг ханган ажиллах илүү хүчирхэг бөгөөд тогтвортой хүний нөөц бүрдүүлэх давуу талтай билээ.



ОЛОН НИЙТ

ХААН Банк нь Банкны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 2021 оны 2 дугаар сараас эхлэн нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажлыг холбогдох хууль, журамд заасан хугацаанд, шат дараатайгаар хийж ирсэн бөгөөд зохицуулагч байгууллагуудаас холбогдох зөвшөөрлүүдийг хүлээн авсны дагуу анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр хийсэн. Банк нийт хувьцааныхаа 10 хувь буюу 191,219,800 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгосон нь Монголын хөрөнгийн зах зээлийн хамгийн өндөр дүнтэй, хамгийн олон захиалга авсан, хамгийн олон хөрөнгө оруулагчидтай, хамгийн хүртээмжтэй анхдагч зах зээлийн арилжаа болсон бөгөөд тус хувьцаа одоо Монголын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдаж байна.



Хувьцаа эзэмшигчдийн эрх

- **Ногдол ашиг авах эрх**

Ногдол ашиг авах эрх бол аливаа компанийн хувьцаа эзэмшигчийн эдлэх ёстой үндсэн эрхүүдийн нэг юм.

- **Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх**

Та хувьцаа эзэмшигчдийн хуралд сууж хэлэлцэх асуудалд өөрийн байр сууриа илэрхийлж, тухайн асуудалд хараат бусаар саналаа өгөх замаар компанийн удирдлагын үйл ажиллагаанд оролцох эрхтэй. Мөн та үйл ажиллагаа болон санхүүгийн нөхцөл байдал, бизнесийн хэтийн төлөвийн талаар баримталж буй бодлого, төлөвлөгөөний талаар чухал хэрэгцээт мэдээлэл авч болно.

- **Банкны тайлан, мэдээлэлтэй танилцах**

Жилийн санхүүгийн үзүүлэлт, БОНЗ, тогтвортой хөгжил болон үйл ажиллагааны тайлан болон хууль тогтоомжид заасан бусад мэдээлэлтэй ХААН Банкны албан ёсны цахим хуудас www.khanbank.com болон МХБ-ийн албан ёсны цахим хуудас www.mse.mn-аас танилцах боломжтой.

- **Кастодиан үйлчилгээ авах буюу кастодианаар дамжуулж хувьцаа эзэмшигчийн эрхээ эдлэх**

- **Эрх ашгаа хамгаалуулах талаар гомдол гаргах**

Та хувьцаа эзэмшигчийн хувьд өөрийн эрх ашиг зөрчигдсөн гэж үзэж байвал Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргаж, эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.

- **Хууль болон Банкны дүрмээр тогтоосон бусад**

Хувьцаа эзэмшигчдийн үүрэг

- Банкны хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа үнэт цаасны хэмжээ (тоо)-г үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх;

- Өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээх;

Хувьцаа эзэмшигч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас Банканд учруулсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

- Санал өгөх эрхээ үндэслэлтэйгээр, шударгаар хэрэгжүүлэх;

- Хувийн эрх ашгаас Банкны эрх ашгийг ямагт дээгүүр тавих;

- Хууль болон Банкны дүрмээр тогтоосон бусад.

Төлөөлөн удирдах зөвлөл

ХААН Банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ" гэх) нь Банкны засаглалыг хариуцах гол субъект юм. ТУЗ нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкнаас баталсан журам, заавар, ХААН Банкны Дүрэм, Компанийн засаглалын кодекс, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох эрх зүйн бичиг баримтыг мөрдөн банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулдаг.

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь ТУЗ-ийн гишүүнд тавигдах Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, зохицуулагч байгууллагуудын холбогдох дүрэм, журамд заасан шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэхийг ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх, хүний нөөцийн асуудал эрхэлсэн хороо шалгаж хяналт тавьдаг. Шалгаруулалтаар сонгогдсон ТУЗ-ийн нэр дэвшигчдийн холбогдох нотлох баримт, мэдээллийг Монголбанканд хүргүүлж зохих зөвшөөрлийг авч ажилладаг. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал хураах кумулятив аргаар сонгох бөгөөд ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох саналыг тус тусад нь тоолно. Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журмыг СЗХ-ны 2020 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 880 дугаар тогтоолоор баталсан.

ХААН Банк ХК-ийн ТУЗ нь тус Банкны хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болон хараат бус гишүүдээс бүрдсэн нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй. ХААН Банк ХК-ийн ТУЗ-ийн даргаар хатагтай Т.Дарьбум, гишүүдээр Харада Ясүнари, Иший Кисабүро, Ц.Баатарсайхан, Д.Хулан, Жон Ло, Ханс Аарт Йонгяанс, А.Тамир, Б.Амарсанаа нарын олон улсын болон Монгол Улсын банк санхүүгийн салбарын арвин туршлагатай мэргэжилтнүүд тус тус ажилладаг. ХААН Банк ХК-ийн ТУЗ-ийн дарга болон гишүүд Банкны гүйцэтгэх удирдлагад ажилладаггүй болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. Банкны зарим чухал үйл ажиллагааны чиглэлүүдэд тусгайлсан хяналт, шалгалтыг нэмэгдүүлж, ажлын үр дүнг сайжруулах зорилгоор ХААН Банкны ТУЗ нь дэргэдээ Аудитын асуудал эрхэлсэн, Эрсдэлийн асуудал эрхэлсэн, Засаглал, цалин урамшууллын асуудал эрхэлсэн болон Нэр дэвшүүлэх, хүний нөөцийн асуудал эрхэлсэн дөрвөн байнгын хороотой ажилладаг. Эдгээр хороод нь өөрсдийн үйл ажиллагааны дүрэм журмыг Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс баталсан холбогдох дүрэм, журам, зааварт нийцүүлэн мөрдөн ажилладаг бөгөөд тус дүрмээр хороод тус бүрийн бүрэн эрх, үүрэг хариуцлагыг тусгасан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн чиг үүрэг

Банкны ТУЗ-ийн бүрэн эрхийг Банкны тухай хууль, Банкны Дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Монголбанкны Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам, Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекс болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан байдаг. Үүнд:

- Банкны үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар асуудлыг шийдвэрлүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан Дүрмийн 5.5 дахь хэсэгт заасны дагуу хувьцаа гаргах;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн баталсан төрөл болон тоонд багтаан Банкны дүрэмд заасан хувьцаанд хамаарахаас бусад үнэт цаас Дүрмийн 5.5 дахь хэсэгт заасны дагуу гаргах;
- Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргах;
- Монголбанкны зөвшөөрснөөр Банкны гүйцэтгэх удирдлагыг томилох, түүний бүрэн эрхийг тогтоох;
- Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Банкны дотоод аудитын нэгжийг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог батлах, удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
- Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
- Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр гаргах, ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;
- Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон Банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоох, тэдгээрийн залгамж халааг бэлтгэх бодлогыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Банкны салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
- Банк өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, зохицуулагч байгууллагуудын журам болон энэхүү Дүрмээр тогтоосон бусад асуудал.

ТУЗ-ийн Ажлын алба

Зохион байгуулалт:

ТУЗ-ийн Ажлын алба нь ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын удирдлагад ажиллах бөгөөд ТУЗ-ийн Ажлын албаны ажилтнууд болон ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаас бүрдэнэ. ТУЗ-ийн Ажлын албаны ажлын дотоод зохион байгуулалтыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга хариуцна. ТУЗ-ийн Ажлын албаны ажилтан нь ажлын байрны тодорхойлолтод заагдсан үүргийг өөрийн биеэр хариуцан ажиллаж, үүргийн биелэлт, үйл явц, үр дүнг тогтоосон хугацаанд ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад тайлагнана.

Чиг үүрэг:

ТУЗ-ийн Ажлын албаны үйл ажиллагааны бодлогод заасны дагуу ТУЗ-ийн Ажлын алба нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах, Банкны засаглалын асуудалд дэмжлэг үзүүлэх, Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах, шаардлагатай мэдээлэл өгөх, тэдгээрийн бодлогын баримт бичиг, дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих, Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн бичиг хэрэг, хуралдааны тэмдэглэл хөтлөх, хуралдаан болон ТУЗ-ийн гишүүдийн сургалтыг тогтмол зохион байгуулах гэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Ногдол ашиг

Ногдол ашиг гэдэг нь эзэмшиж буй хувьцааны тоо ширхэгт ногдох ашгийн хувь хэмжээг хэлнэ.

ХААН Банк ХК нь холбогдох хууль тогтоомж болон Банкны Дүрэм, Ногдол ашгийн бодлогод заасны дагуу ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргадаг бөгөөд санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногт буюу жил бүрийн 2 дугаар сарын 19-ний өдрийн дотор гаргаж олон нийтэд мэдээлдэг.

Ногдол ашиг хуваарилах ТУЗ-ийн шийдвэрт дараах мэдээллийг тусгана:

- Хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ
- Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр
- Ногдол ашиг төлөх өдөр

Хэрэв ногдол ашиг хуваарилахгүй гэж үзвэл ТУЗ нь энэ шийдвэрийн үндэслэл, шалтгаан, хөрөнгө санхүүгийн тооцоолол зэргийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнах үүрэгтэй.

Банк нь нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилдаг. Банкны жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:

- Банкны тухай хуулийн 35.3-т заасны дагуу Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлт хангагдах нөхцөлд ногдол ашиг хуваарилах буюу Монголбанкнаас зөвшөөрөл олгосон тохиолдолд (Банкны Нягтлан бодох бүртгэлийн зааврын 6.6-д заасны дагуу)
- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх
- Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх
- Ногдол ашиг төлсний дараа өөрийн хөрөнгийн хэмжээ нь Компанийн тухай хуулийн 30.5-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх

Холбоо барих

Хөрөнгө оруулагч та дараах сувгаар санал хүсэлт, гомдлоо ирүүлэх боломжтой.

Хаяг	ХААН Банк Цамхаг, Чингисийн Өргөн Чөлөө-6, Стадион Оргил-1, Хан-Уул Дүүрэг 15-р хороо, Улаанбаатар 17010, Монгол Улс
Утас	7515-3333 (3221)
ХААН Банкны албан ёсны цахим хуудас	https://www.khanbank.com/
"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн албан ёсны цахим хуудас	https://mse.mn/mn
И-мэйл	Investor_relations@khanbank.com



www.khanbank.com
investor_relations@khanbank.com



1800-1917
7515-3333 (3221)



facebook.com/khanbank
twitter.com/khan_bank